



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/6023

Арвайхээр

Зарим арга хэмжээг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8, 32 дугаар зүйлийн 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 57 дугаар хуралдааны тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 40 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бүх шатны төрийн байгууллага, нутгийн зөвлөл, мэргэжлийн холбоодын болон олныг хамарсан “Шинэ жилийн баяр”-ын үйл ажиллагааг тэмдэглэхийг хориглосугай.

2. Коронавируст халдвар Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөвхөн гэр бүлийн гишүүдийн хүрээнд “Шинэ жилийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхийг иргэдэд уриалсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101335